



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 12 дугаар сарын 13

№ 01/92

Мандалговь хот

**Г Зөрчил арилгуулах тухай Г**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээ, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн аудитын журмын 1.9 дэх заалт, аймгийн Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрцогт сумын Эрүүд мэндийн төвийн 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

1. Шатахууны тооцоо бодож баталгаажуулаагүй 6,696,140.00 /Зургаан сая зургаан зуун ерэн зургаан мянга нэг зуун дөчин / төгрөгийн шатахууныг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 73 дугаар зүйл 73.2-д / Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана. /, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1-р хавсралт /Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д/Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-т /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нормативт зардлыг хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Лувсандагва, нягтлан бодогч Б.Ууганцэрэн нарт хариуцуулав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup> :



ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ [Signature] Д.ЛУВСАНДАГВА  
НЯГТЛАН БОДОГЧ [Signature] Б.УУГАНЦЭРЭН

<sup>1</sup>Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ./